



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/23

Ховд

Үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 103 дугаар журам, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын А/03 дугаар журмуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Барилга хот байгуулалтын яамнаас эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Халуун усны барилга (Ховд аймаг, Ховд, Буянт сум)-ын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Н.Эрдэнэцэцэг - Худалдан авах ажиллагааны албаны ахлах мэргэжилтэн

Гишүүдэд: Б.Батчимэг - Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн нягтлан

Д.Батцэцэг - Төрийн бус байгууллагын төлөөлөл

Т.Бямбатөмөр - Иргэний төлөөлөл

Нарийн бичиг: Д.Дариймаа - Худалдан авах ажиллагааны албаны мэргэжилтэн

2. Үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл авах, тендер шалгаруулалтыг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулан явуулж үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (Н.Эрдэнэцэцэг)-д даалгасугай.

3. Дээрх төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэхийг үнэлгээний хорооны нарийн бичиг (Д.Дариймаа)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Д.ЭНХБОЛД

8401 03 0163

D\Tush-A\23-Bo